



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь: “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын исэлдсэн хүдрийн болон тодорхой нөхцөлд үр ашигтай буюу ядуу агуулгатай хүдрийн овоолгын ашиглалтын байдал, цаашид авах арга хэмжээний талаарх Ажлын хэсгийн танилцуулга

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ерөнхий захирал Х.Бадамсүрэнд даалгах нь:

1.1 Ачит Ихт ХХК-тай байгуулсан гэрээнүүдийн хэрэгжилт, 2010 оны “Гэрээ”-ний 5.1, 2013 оны “Хамтран ажиллах гэрээ”-ний 2.2 дахь заалтуудад тусгагдсан Эрдэнэт үйлдвэр 34 хувь эзэмших тухай асуудлаар хууль зүйн дүгнэлт хийж, Эрдэнэт үйлдвэрийн авч болох байсан ногдол ашиг, алдагдсан боломжийн тооцооллыг Ажлын хэсэгт танилцуулах,

1.2 “Эрдмин” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын хувь эзэмшлийн хэмжээ, ногдол ашгийн хуваарилалт, дүрмийн санг бүрдүүлсэн “Марубени” корпорацийн хөрөнгө оруулалт, зээлийн эргэн төлөлттэй холбоотой асуудлыг судлан дүгнэлт гаргаж, Ажлын хэсэгт танилцуулах,

1.3 “Эрдмин” ХХК-ийн ашиглаж буй газрын төлбөрийн асуудлыг нягталж, төлбөр нэхэмжлэх, цаашид газар ашиглуулах гэрээ байгуулах эсэх асуудлыг судлан шийдвэрлэх,

1.4 Исэлдсэн хүдрийн болон тодорхой нөхцөлд үр ашигтай буюу ядуу агуулгатай хүдрийн овоолгуудын ашиглалтыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т ашигтай байх нөхцөлөөр хамтран ажиллах талаар “Ачит Ихт” ХХК, “Эрдмин” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК, “Эрдэнэт уулын өгөөж” ХХК-иудтай уулзалт хийж, уулзалтын талаарх мэдээлэл, тэмдэглэлийг Ажлын хэсэгт танилцуулах.

2. Хурлын үеэр гишүүдийн гаргасан санал болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т хуралдаанаас үүрэг болгосон асуудлыг нэгтгэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан танилцуулахыг Ажлын хэсэг (А.Ариунболд)-т даалгав” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132002006